



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 5 нэрийн нийт 148,843,611.11 (нэг зуун дөчин найман сая найман зуун дөчин гурван мянга зургаан зуун арван нэгэн төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 63,432,810.00 (жаран гурван сая дөрвөн зуун гучин хоёр мянга найман зуун арван) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Т.Ган-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 9 дугаар сарын 27-ны өдрийн
 119 дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА
 БОЛОН ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Балансын нэгж үнэ /төгрөг/	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жил/	Шинэчлэн тогтоох үнэ /төгрөг/
1	Автомашин УАЗ-390992 фургон, улсын дугаар 59-73 СҮА	2012-06-30	1	20,000,000.00	20,000,000.00	2	10,000,000.00
2	Автомашин Toyota land cruiser 76 жип, улсын дугаар 3538 СҮА	2014-06-14	1	94,200,000.00	94,200,000.00	3	47,100,000.00
3	Зурагт 42 инч	2016-01-01	1	460,000.00	460,000.00	2	230,000.00
4	Ноос пресслэгч	2013-09-26	5	5,494,500.00	27,472,500.00	2	2,747,250.00
5	Ноос пресслэгч	2013-09-26	1	6,711,111.11	6,711,111.11	2	3,355,560.00
					148,843,611.11		63,432,810.00
НИЙТ ДҮН					(нэг зуун дөчин найман сая найман зуун дөчин гурван мянга зургаан зуун арван нэгэн төгрөг арван нэгэн мөнгө)		(жаран гурван сая дөрвөн зуун гучин хоёр мянга найман зуун арван төгрөг)